



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

“Үндэсний давхар даатгал”
хувьцаат компанийн дүрэмд
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.1.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 3.1 дэх хэсгийн “200 000 000 /хоёр зуун сая/” гэснийг “245 000 000 /хоёр зуун дөчин таван сая/” гэж, “20 000 000 000 /хорин тэрбум/” гэснийг “24 500 000 000 /хорин дөрвөн тэрбум таван зуун сая/” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан шинэчилсэн дүрмийн өөрчлөлтийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Ванчинхүү/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /С.Наранцогт/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ
САНГИЙН САЙД



Ч.ХҮРЭЛБААТАР

9767 00197

“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Үндэсний давхар даатгал” хаалттай хувьцаат компани /цаашид “компани” гэх/-ийн энэхүү дүрмээр Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасан заавал тусгах зүйлээс гадна хуульд нийцүүлэн бусад хэм хэмжээг тогтооход оршино.

1.2. Компани нь давхар даатгалын үйл ажиллагааг Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу давхар даатгалын үйл ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэнэ.

1.3. Компани нь үйл ажиллагаандаа Монголын компанийн засаглалын кодексыг удирдлага болгон ажиллана.

1.4. Компанийн үйл ажиллагаа хугацаагүй байх бөгөөд холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасны дагуу өөрчлөн байгуулж, татан буулгаж болно.

Хоёр. Компанийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, нэршил, байршил

2.1. Компанийн үндсэн зорилго нь даатгалын мэргэжлийн байгууллагууд болон даатгуулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий давхар даатгалын бүтээгдэхүүнийг гадаад дотоодын санхүүгийн зах зээлд санал бслгон худалдах, оролцогч талуудын хууль ёсны ашиг сонирхлыг хангах зэргээр Монгол улсын даатгалын салбарын үйл ажиллагааг өргөтгөх, хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад оршино.

2.2. Компани нь дараах чиглэлийн хүрээнд хуулийн дагуу үйл ажиллагааг эрхэлнэ:

2.2.1. Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу хуулиар зөвшөөрсөн давхар даатгалын болон даатгалтай холбоотой бусад үйл ажиллагаа эрхлэх.

2.2.2. Тусгай зөвшөөрөлтэй давхар даатгалын компанийн эрхэлж болох бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

2.2.3. Үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор даатгалын зах зээл дээр сургалт, судалгаа, сурталчилгаа явуулах зэргээр хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа эрхэлнэ.

2.3. Компанийн албан ёсны оноосон нэрийг монгол хэлээр “Үндэсний давхар даатгал” хувьцаат компани, англи хэлээр “Mongolian National Reinsurance” Joint Stock Company, компанийн товчилсон нэрийг (монгол хэлээр): “ҮДД” ХК, (англи хэлээр): “Mongolian Re” JSC гэж бичнэ.

2.4. Компани нь өөрийн үйл ажиллагаа, бүрэн эрхийг хэрэгжүүлэх, гэрээ хэлцэл хийх зэрэг бүхий л тохиолдолд оноосон нэрний дараа “ХК” гэсэн товчлолыг хэрэглэнэ.

2.5. Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, барааны тэмдэг, бэлгэдэлтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-өөр батлуулж холбогдох байгууллагад бүртгүүлж, ашиглах эрхийг зөвхөн компани эзэмшинэ.

2.6. Компанийн ерөнхий захиргааны байрлах албан ёсны хаяг. Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө, 10-б байр Бизнес тауэр, 20 давхар, 2001 тоот байх бөгөөд цаашид хаяг өөрчлөх тохиолдолд асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

Гурав. Компанийн хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгө

3.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 245 000 000 /хоёр зуун дөчин таван сая/ ширхэг энгийн хувьцаа /цаашид “хувьцаа” гэх/-тай байх ба нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 24 500 000 000 /хорин дөрвөн тэрбум таван зуун сая/ төгрөг байна.

3.2. Компани хувьцаа нэмж гаргах, зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх, төрийн өмчлөл дэх хувьцааг бусдад худалдах зэрэг асуудлаар хувьцаа эзэмшигч санал боловсруулж Засгийн газраар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж болох бөгөөд хувьцааны борлуулалтын орлогыг мөнгөн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

Дөрөв. Компанийн удирдлага

4.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал:

4.1.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг зарласан хувьцааг гаргах хүртэл Сангийн сайд хэрэгжүүлнэ.

4.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр Сангийн сайдын тушаал хэлбэртэй байна.

4.1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал бүрэн эрхээ Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөл:

4.2.1. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус гишүүн байна.

4.2.2. ТУЗ-ийн ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.

4.2.3. ТУЗ бүрэн эрхээ Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2 дахь хэсэгт заасны дагуу хэрэгжүүлнэ.

4.2.4. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын төслийг ТУЗ батална.

4.2.5. ТУЗ-ийн гишүүнийг Компанийн тухай хуулийн 77.1-д заасны дагуу болон компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу сонгоно.

4.2.6. ТУЗ-ийн даргыг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр томилж чөлөөлнө.

4.2.7. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх, түүний эрх үүргийг Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйл болон компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

4.2.8. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаа, эрх хэмжээг мөн хуулийн 82 дугаар зүйл болон компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тус тус зохицуулна.

4.2.9. Сангийн сайд шаардлагатай гэж үзвэл дээрх журмын төсөлд өөрчлөлт оруулахыг ТУЗ-өөс шаардаж болно.

4.3. Гүйцэтгэх удирдлага:

4.3.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

4.3.2. Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

4.3.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

4.3.4. Гүйцэтгэх захирлыг тодорхой тавигдах шаардлагын үндсэн дээр нээлттэй сонгон шалгаруулах асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-



ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ын нарийн бичгийн даргатай хамтран зохион байгуулж ажиллана.

4.3.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй Компанийн тухай хуулийн 83.7 дахь хэсэгт заасны дагуу гэрээ байгуулан ажиллана.

4.3.6. Компани дэд захиралтай байх бөгөөд Гүйцэтгэх захирал ТУЗ-д нэрийг нь дэвшүүлж томилуулна.

Тав. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

5.1. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.

5.2. Компани нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон эрх бүхий байгууллагуудаас тогтоосон нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн хөтөлнө.

5.3. Компанийн Гүйцэтгэх захирал жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Компанийн тухай хуулийн 96.4 дэх хэсэгт заасан зүйлийг тусган хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болохоос 1 сарын өмнө ТУЗ-д танилцуулна.

Зургаа. Хөндлөнгийн аудит болон актуарчийн хяналт

6.1. Компанийн тухай хуулийн 94.1 дэх хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 24.4 дэх хэсэгт заасны дагуу бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор ТУЗ-ийн сонгож шийдвэрлэсэн хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэнэ.

Долоо. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

7.1. Компанийг өөрчлөн байгуулахыг компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлээр, өрийг хувьцаагаар солихыг мөн хуулийн 25 дугаар зүйлээр, компанийг татан буулгахыг мөн хуулийн 26-29 дүгээр зүйлээр тус тус шийдвэрлэнэ.

Найм. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах

8.1. Шаардлагатай тохиолдолд компанийн дүрэмд өөрчлөлт оруулж болох бөгөөд дүрмийн төслийг гүйцэтгэх удирдлага боловсруулж ТУЗ-д танилцуулан саналыг нь авсны үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.

8.2. Дүрэмд өөрчлөлт оруулахад Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийг дагаж мөрдөнө.

Ес. Бусад

9.1. Энэхүү дүрэмд заагаагүй бусад харилцааг Компанийн тухай хууль болон холбогдох тогтоомж, эрх зүйн актаар зохицуулна.

--ooOoo--

